

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/104/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2024 он	Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: Baasansurens@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12-13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13-14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-16
4. Аудитын тайлан	16-20
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17-18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шитгэл



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА Б.САРУУЛТӨГС ТАНАА

2024.02.16 № СӨА-2024/104/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

ГЗБГЗЗГ-ын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 1/2453 дугаар албан бичгийг үндэслэн тус газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/17 дугаар тушаалаар албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 07 дугаар сараас 40 хувиар тооцож, нийт 54,805.5 мянган төгрөгийг нөхөн олгосон байна.

Аудитын гол асуудал

Тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн барилгын техник хяналтын захиалагчийн хяналтын 67,855.6 мянган төгрөгийн зарцуулалтын эрхийг эдийн засгийн ангиллаар бус бараа үйлчилгээний бусад зардлын ангилалд бөөн дүнгээр тавьж байгаа нь хөрөнгийн зарцуулалтад зардлын бүлгээр тавих хяналтыг сулруулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус газар нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 13 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 93.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглээний эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	34,999,096.00	82,385,463.72
33	АВЛАГА	1,238,822.00	53,501,629.72
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,238,822.00	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	53,501,629.72
35	БАРАА МАТЕРИАЛ	33,760,274.00	28,883,834.00
35400	Хангамжийн материал	33,760,274.00	28,883,834.00
35410	Бичиг хэргийн материал	3,558,250.00	2,693,850.00
35420	Аж ахуйн материал	28,522,174.00	21,038,984.00
35440	Түлш, шатах тослох материал	251,000.00	4,071,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,428,850.00	1,080,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	381,939,574.81	341,011,893.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	381,939,574.81	341,011,893.37
39200	Биет хөрөнгө	363,721,574.81	322,793,893.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	120,724,015.00	120,724,015.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4,073,070.72)	(6,801,338.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	264,200,000.00	264,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(111,029,166.88)	(155,354,166.73)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	281,807,669.00	315,167,911.60
39206	Хуримтлагдсан элэгдэл	(197,658,398.74)	(242,023,252.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,239,389.00	38,135,084.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,488,861.85)	(11,254,359.83)
39300	Биет бус хөрөнгө	18,218,000.00	18,218,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18,218,000.00	18,218,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	416,938,670.81	423,397,357.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	416,938,670.81	423,397,357.09
51	Засгийн газрын хувь оролцоо	416,938,670.81	423,397,357.09
51100	Засгийн газрын оруулсан капитал	157,557,480.26	157,557,480.26
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	157,557,480.26	157,557,480.26
51200	Хуримтлагдсан үр дүн	252,813,425.55	259,272,111.83
51210	Өмнөх үеийн үр дүн	(159,549,302.18)	251,574,603.55
51220	Тайлант үеийн үр дүн	412,362,727.73	7,697,508.28
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,567,765.00	6,567,765.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	416,938,670.81	423,397,357.09

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,312,007,711.26	1,272,287,687.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	655,892,359.26	164,187,523.18
120	Нийтлэг татварын бус орлого	655,892,359.26	164,187,523.18
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	124,972,806.00	158,865,184.86
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	124,972,806.00	158,865,184.86

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	477,267,839.26	5,322,338.32
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	53,651,714.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	656,115,352.00	1,108,100,164.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	537,984,500.00	1,038,785,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	537,984,500.00	1,038,785,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	117,895,252.00	69,095,664.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,485,800.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	92,909,452.00	68,095,664.50
1330	Төсвийн захирагчдаас	235,600.00	219,000.00
133003	Хөрөнгийн	235,600.00	219,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	895,338,243.53	1,264,590,179.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	895,338,243.53	1,264,590,179.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	757,918,047.77	1,208,577,895.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	425,266,394.03	845,626,361.06
210101	Үндсэн цалин	340,728,515.15	524,034,377.15
210102	Нэмэгдэл	63,440,872.92	221,200,167.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,971,370.18	40,563,926.93
210104	Урамшуулал	7,869,635.78	59,827,889.94
210105	Гэрээт ажлын хөлс	3,256,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,517,308.29	106,131,577.92
210201	Тэтгэврийн даатгал	35,275,597.48	72,644,540.52
210202	Тэтгэмжийн даатгал	4,107,861.40	8,507,962.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,279,569.12	6,770,432.74
210204	Ажилгүйдлийн даатгал	819,892.27	1,651,858.68
210205	Эрүүл мэндийн даатгал	8,034,388.02	16,556,783.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,848,450.00	3,175,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,740,200.00	-
210302	Түлш, халаалт	1,950,550.00	-
210303	Цэвэр, бохир ус	2,065,800.00	-
210304	Байрны түрээс	5,091,900.00	3,175,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,834,100.00	40,832,640.00
210401	Бичиг хэрэг	14,853,070.00	8,793,910.00
210402	Тээвэр, шатахуун	28,722,960.00	17,349,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	446,420.00	269,280.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,080,750.00	3,187,710.00
210408	Бараа материал акталсны зардал	13,730,900.00	11,232,740.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,960,300.00	21,648,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	110,000.00
210604	Урсгал засвар	55,960,300.00	21,538,000.00
2107	Томилолт, зочны зардал	16,928,500.00	12,801,830.00
210702	Дотоод албан томилолт	16,928,500.00	12,801,830.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,533,730.00	83,967,966.52

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,427,630.00	83,894,986.52
210803	Даатгалын үйлчилгээ	106,100.00	52,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	7,900.00
210807	Газрын төлбөр	-	13,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	107,029,265.45	94,394,519.76
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	841,301.00	210,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	106,187,964.45	94,183,619.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,420,195.76	56,012,284.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,450,000.00	3,900,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,450,000.00	3,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,825,532.76	44,036,269.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,476,167.68	18,852,114.50
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,349,365.08	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	25,184,155.14
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	8,076,014.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,076,014.50
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	127,144,663.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	127,144,663.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	416,669,467.73	7,697,508.28
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,306,740.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	4,306,740.00	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	412,362,727.73	7,697,508.28

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	784,498,649.08	1,213,244,719.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	124,972,806.00	105,363,555.14
120	Нийтлэг татварын бус орлого	124,972,806.00	105,363,555.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	124,972,806.00	105,363,555.14
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	124,972,806.00	105,363,555.14
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	659,525,843.08	1,107,881,164.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	537,984,500.00	1,038,785,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	537,984,500.00	1,038,785,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	121,232,373.08	69,095,664.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,485,800.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	1,000,000.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	96,246,573.08	68,095,664.50
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	308,970.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	308,970.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	773,638,949.08	1,165,311,119.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	773,638,949.08	1,165,311,119.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	635,909,783.32	1,109,298,835.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	423,526,602.32	845,625,922.06
210101	Үндсэн цалин	332,920,531.44	524,033,938.15
210102	Нэмэгдэл	69,509,064.92	221,200,167.04
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,971,370.18	40,563,926.93
210104	Урамшуулал	7,869,635.78	59,827,889.94
210105	Гэрээт ажлын хөлс	3,256,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,257,100.00	106,132,016.92
210201	Тэтгэврийн даатгал	36,889,100.00	72,644,799.52
210202	Тэтгэмжийн даатгал	4,092,000.00	8,508,142.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,273,600.00	6,770,432.74
210204	Ажилгүйдлийн даатгал	818,400.00	1,651,858.68
210205	Эрүүл мэндийн даатгал	8,184,000.00	16,556,783.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,848,450.00	3,175,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,740,200.00	-
210302	Түлш, халаалт	1,950,550.00	-
210303	Цэвэр, бохир ус	2,065,800.00	-
210304	Байрны түрээс	5,091,900.00	3,175,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,837,800.00	29,617,886.52
210401	Бичиг хэрэг	13,846,770.00	8,819,676.52
210402	Тээвэр, шатахуун	24,751,960.00	17,349,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	446,420.00	269,280.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,792,650.00	3,179,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,605,630.00	25,797,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	748,880.00	4,228,000.00
210604	Урсгал засвар	63,856,750.00	21,569,000.00
2107	Томилолт, зочны зардал	16,928,500.00	12,801,830.00
210702	Дотоод албан томилолт	16,928,500.00	12,801,830.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,153,500.00	85,938,280.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,958,300.00	85,865,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	195,200.00	52,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	7,900.00
210807	Газрын төлбөр	-	13,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	752,201.00	210,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	752,201.00	210,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	137,729,165.76	56,012,284.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,758,970.00	3,900,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	308,970.00	-

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,450,000.00	3,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,825,532.76	44,036,269.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,476,167.68	18,852,114.50
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,349,365.08	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	25,184,155.14
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	8,076,014.50
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,076,014.50
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	127,144,663.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	127,144,663.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,859,700.00	47,933,600.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,859,700.00	47,933,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,859,700.00	47,933,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,859,700.00	47,933,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,859,700.00	47,933,600.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(10,859,700.00)	(47,933,600.00)

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	157,557,480.26	6,567,765.00	(159,549,302.18)	4,575,943.08
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	(159,549,302.18)	4,575,943.08
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	412,362,727.73	412,362,727.73
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	252,813,425.55	416,938,670.81
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	252,813,425.55	416,938,670.81

12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,238,822.00)	(1,238,822.00)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	251,574,603.55	415,699,848.81
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	7,697,508.28	7,697,508.28
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	157,557,480.26	6,567,765.00	259,272,111.83	423,397,357.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,133,785,500.00	1,100,112,785.50	33,672,714.50	97.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,133,785,500.00	1,100,112,785.50	33,672,714.50	97.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,130,830,700.00	1,097,212,785.50	33,617,914.50	97.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	863,247,500.00	845,625,922.06	17,621,577.94	97.96
210101	Үндсэн цалин	505,495,200.00	524,033,938.15	(18,538,738.15)	103.67
210102	Нэмэгдэл	293,229,700.00	221,200,167.04	72,029,532.96	75.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,649,000.00	40,563,926.93	4,085,073.07	90.85
210104	Урамшуулал	19,873,600.00	59,827,889.94	(39,954,289.94)	301.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,509,500.00	106,132,016.92	2,377,483.08	97.81
210201	Тэтгэврийн даатгал	73,786,400.00	72,644,799.52	1,141,600.48	98.45
210202	Тэтгэмжийн даатгал	8,680,800.00	8,508,142.06	172,657.94	98.01
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,944,600.00	6,770,432.74	174,167.26	97.49
210204	Ажилгүйдлийн даатгал	1,736,200.00	1,651,858.68	84,341.32	95.14
210205	Эрүүл мэндийн даатгал	17,361,500.00	16,556,783.92	804,716.08	95.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,797,700.00	3,175,000.00	7,622,700.00	29.40
210301	Гэрэл, цахилгаан	2,183,400.00	-	2,183,400.00	0.00
210302	Түлш, халаалт	3,414,400.00	-	3,414,400.00	0.00
210303	Цэвэр, бохир ус	2,024,900.00	-	2,024,900.00	0.00
210304	Байрны түрээс	3,175,000.00	3,175,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,649,100.00	18,798,116.52	850,983.48	95.67
210401	Бичиг хэрэг	7,970,900.00	7,126,826.52	844,073.48	89.41
210402	Тээвэр, шатахуун	10,719,000.00	10,719,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	511,600.00	269,280.00	242,320.00	52.63

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	447,600.00	683,010.00	(235,410.00)	152.59
2105	Нормативт зардал	168,200.00	-	168,200.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	168,200.00	-	168,200.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,273,900.00	30,229,700.00	44,200.00	99.85
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000,000.00	9,955,800.00	44,200.00	99.56
210604	Урсгал засвар	20,273,900.00	20,273,900.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	12,907,100.00	12,801,830.00	105,270.00	99.18
210702	Дотоод албан томилолт	12,907,100.00	12,801,830.00	105,270.00	99.18
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,066,800.00	80,239,300.00	4,827,500.00	94.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	85,006,900.00	80,179,400.00	4,827,500.00	94.32
210803	Даатгалын үйлчилгээ	52,000.00	52,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	7,900.00	7,900.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	210,900.00	210,900.00	-	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	210,900.00	210,900.00	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,954,800.00	2,900,000.00	54,800.00	98.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,954,800.00	2,900,000.00	54,800.00	98.15
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	2,954,800.00	2,900,000.00	54,800.00	98.15
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,133,785,500.00	1,144,149,055.14	(10,363,555.14)	100.91
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,038,785,500.00	1,038,785,500.00	-	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,038,785,500.00	1,038,785,500.00	-	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	95,000,000.00	105,363,555.14	(10,363,555.14)	110.91
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	95,000,000.00	105,363,555.14	(10,363,555.14)	110.91
	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1.00	1.00	-	100.00
	Байгууллагын тоо	1.00	1.00	-	100.00
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43.00	37.00	6.00	86.05
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
	Гүйцэтгэх ажилтан	38.00	32.00	6.00	84.21
	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	69,095,664.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	69,095,664.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,019,650.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,819,770.00

210401	Бичиг хэрэг	1,692,850.00
210402	Тээвэр, шатахуун	6,630,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,496,920.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,645,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,500,000.00
210602	Тавилга	19,850,000.00
210604	Урсгал засвар	1,295,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,554,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,541,700.00
210807	Газрын төлбөр	13,080.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,000,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	1,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,076,014.50
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	8,076,014.50
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	69,095,664.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	69,095,664.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	68,095,664.50

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газар /цаашид аймгийн ГХБХБГ гэх/ нь 2023 онд “Сэлэнгэ аймгийн газар нутгийн нөөц чадавхыг дэмжин тэтгэсэн эдийн засгийн хувьд ашигтай, экологийн хувьд тэнцвэртэй газар ашиглалтын бодлогыг хэрэгжүүлж, эрх зүйн баталгаатай газар өмчлөл, эзэмшилт, ашиглалтыг бий болгоно.” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд ГЗБГЗЗГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс хяналт тавьж ажилладаг бөгөөд 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд дурдагдсан алдаа, зөрчил, аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт болон шилэн дансны хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэх ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ГХБХБГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь ГЗБГЗЗГ-ын даргын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/157 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Аймгийн ГХБХБГ-ын мөрдөж байгаа “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн ГХБХБГ нь 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,458.6 мянган төгрөгөөр буюу 1.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,238.8	53,501.6	52,262.8
Бараа материал	33,760.3	28,883.8	(4,876.5)
Үндсэн хөрөнгө	381,939.6	341,011.9	(40,927.7)
Нийт хөрөнгө	416,938.7	423,397.3	6,458.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	416,938.7	423,397.3	6,458.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	416,938.7	423,397.3	6,458.6

Дээрх хүснэгтээс үзэхэд нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данс байна.

Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 52,262.8 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны 1,238.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, Барилгын хөгжлийн төвөөс авах барилга захиалагчийн техник хяналтын 53,501.6 мянган төгрөгийн авлага үүсгэснээс,
- Бараа материалын дансны үлдэгдэл 28,883.8 мянган төгрөг болж 4,876.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 86,090.6 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, ГЗБГЗЗГ-аас 219.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 79,953.3 мянган төгрөгийн материалыг зарцуулж, тус газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар 11,232.7 мянган төгрөгийн аж ахуйн материалыг акталж, устгаснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 341,011.9 мянган төгрөг болж 40,927.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 47,933.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, 5,322.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй хүлээн авсан болон 94,183.6 мянган төгрөгийн элэгдлийг нэмж байгуулснаас тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Аймгийн ГХБХБГ нь 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,997,091.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар бууруулж баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 110,309.8 мянган төгрөг,
- Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 13,788.7 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 6,939.9 мянган төгрөг зэрэг нийт **131,038.4** мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 28,404.0 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардлыг 31,507.7 мянган төгрөг,
- Нормативт зардлыг 14,231.8 мянган төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 116,966.1 мянган төгрөг,
- Томилолт, зочны зардлыг 6,898.9 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 1,789.1 мянган төгрөг,
- Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардлыг 845.2 мянган төгрөг,
- Лабораторийн барилга шинээр барихаар төлөвлөсөн 2,100,000.0 мянган төгрөг зэрэг нийт 2,300,642.8 мянган төгрөгөөр бууруулж 827,487.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 306,298.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн төсвийн тодотгол, зохицуулалт хийж /Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 232,265.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 29,033.3 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 1,587.2 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 2,668.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 42,272.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, байр ашиглахтай холбоотой зардлыг 1,527.3 мянган төгрөгөөр бууруулсан байна./ 1,133,785.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,038,785.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 95,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, гүйцэтгэлээр 1,038,785.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 95,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэн урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,100,112.8 мянган төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 33,672.7 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,035,830.7	1,002,212.8	(33,617.9)	96.7
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшил	2,954.8	2,900.0	(54.8)	98.1
3	Барилгын техник хяналт	95,000.0	95,000.0	-	100.0
	Дүн	1,133,785.5	1,100,112.8	(33,672.7)	97.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130029401 тоот дансанд нийт 69,095.6 мянган төгрөг /Барилгын техник хяналтын захиалагчийн хяналтын орлогоос 67,855.6 мянган төгрөг, 2022 оны ажлын гүйцэтгэл, үр дүнгээр 3 дугаар байранд шалгарсны шагнал 1,000.0 мянган төгрөг, ирээдээс эзэмшил газрын эргэлтийн цэг тогтоолгосны тэмдэгтийн үнэ 240.0 мянган төгрөг/-ийн санхүүжилт төвлөрч, 61,019.6 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 8,076.0 мянган төгрөгийг жилийн эцэст ГЗБГЗЗГ-т төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу аймгийн ГХБХБГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ГХБХБГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 895,338.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,953.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд тус газрын батлагдсан төсөвт материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,264,590.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 12,645.9 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд тус газар нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 17,621.6 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 2,377.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 7,622.7 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 850.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 4,827.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд аймгийн ГХБХБГ-ын мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны

тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт/ нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал гараагүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,238.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй 1 зөрчилд албан шаардлага, бараа материалыг ангиллын дагуу бүртгээгүй 1 зөрчилд зөвлөмж өгснийг нотлох баримттай тулган баталгаажуулахад бүрэн биелсэн байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	1,238.8	1	1,238.8	100.0
Зөвлөмж	1		1		100.0
Нийт дүн	2	1,238.8	2	1,238.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус газрын төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1.ГЗБГЗЗГ-ын 2023 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 1/2453 дугаар албан бичгийг үндэслэн тус газрын даргын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/17 дугаар тушаалаар албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 07 дугаар сараас эхлэн сар бүр 40 хувиар тооцож, нийт 54,805.5 мянган төгрөгийг нөхөн олгосон байна.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,270.0 мянган төгрөгийн 3 зөрчил илэрч нөхөн төлбөрийн акт тогтоов.

5.1 Төлбөрийн акт

1. Албан хаагчдын Улаанбаатар хот болон сумдад албан томилолтоор ажилласан хугацаанд нийт 2,220.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг давхардуулан тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5. ... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон хоолны хөнгөлөлтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тус газарт гэрээгээр ажиллаж байгаад 12 дугаар сарын 11-ний өдрөөс хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтнээр түр томилогдсон А.Жамбалдоржийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж, дүгнэлгүйгээр нэг сарын үндсэн цалин буюу 1,100.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ын өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлд “... ажилтныг **ажлын үр дүнг нь харгалзан үзэж** нэг сарын үндсэн цалингийн 100 хүртэл хувиар тооцож урамшуулах ...” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж, дүгнэлгүйгээр олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Тус газрын ерөнхий нягтлан бодогч Б.Уранчимэгийн өмнөх оны ажлыг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 40.0 хүртэл хувиар тооцож үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр нэг сарын үндсэн цалин буюу 950.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3. “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал	Тоо	Дүн
Унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан тооцож олгосон.	1	2,220.0	1	2,220.0								
Ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлж, дүгнэлгүйгээр урамшуулал олгосон.	1	1,100.0	1	1,100.0								
Үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон.	1	950.0	1	950.0								
Дүн	3	4,270.0	3	4,270.0	-	-	-					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-